

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2023 оны II улирлын санхүүгийн тайлан

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын
IV байр. Утас: 51-261668 Цахим шуудан: nbfi@frc.mn

Агуулга

Хүснэгтийн жагсаалт.....	3
Зургийн жагсаалт.....	4
Товчилсон нэрсийн жагсаалт	4
Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал.....	5
Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт	7
Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт.....	7
Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт	8
Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт.....	8
“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт	8
Статистик үзүүлэлтүүд	9
Харилцагчид, зээлдэгчид.....	9
Хувьцаа эзэмшигчид болон ажилчид	9
Тархалт	10
Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт.....	11
Мөнгөн хөрөнгө.....	12
Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	12
Факторингийн тооцооны авлага.....	13
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө	13
Зээл.....	14
Цахим зээл	16
Ногоон зээл	18
Бусад хөрөнгө	19
Эргэлтийн бус хөрөнгө	19
Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт.....	20
Итгэлцлийн үйлчилгээний өглөг.....	21
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	22
Бусад эх үүсвэр	22
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	22
Төслийн зээлийн санхүүжилт.....	23
Бусад өр төлбөр	24
Хувь нийлүүлсэн хөрөнгө.....	24
Бусад өмч, сангууд	25
Хуримтлагдсан ашиг	25
Хоёрдогч өглөг.....	26
Ашигт ажиллагаа	26
Гадаад валютын арилжааны мэдээ	28
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд.....	29
Дүгнэлт	30
Актив, пассивын бүтэц.....	30
Ашигт ажиллагаа	31
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	31

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл	5
Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/	5
Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа	5
Хүснэгт 5 Харилцагч, зээлдэгчдийн мэдээлэл.....	9
Хүснэгт 6 Статистик мэдээлэл /5 жилээр/.....	9
Хүснэгт 7 ББСБ-ын мэдээлэл	10
Хүснэгт 8 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа.....	10
Хүснэгт 9 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт	10
Хүснэгт 10 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт	10
Хүснэгт 11 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/	11
Хүснэгт 12 Активын интервал /тэрбум төгрөгөөр/	12
Хүснэгт 13 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	12
Хүснэгт 16 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/.....	13
Хүснэгт 17 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/.....	13
Хүснэгт 18 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/	13
Хүснэгт 19 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	14
Хүснэгт 20 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /сая төгрөгөөр/.....	15
Хүснэгт 21 Зээлийн ангилал /тэрбум төгрөгөөр/.....	16
Хүснэгт 22 Зээлийн ангилал	16
Хүснэгт 23 Цахим зээл олгож байгаа ББСБ-ууд	16
Хүснэгт 24 Ногоон зээлийн тайлан /сая төгрөгөөр/	18
Хүснэгт 25 Бусад хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/.....	19
Хүснэгт 26 Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	19
Хүснэгт 27 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/	20
Хүснэгт 28 Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/	21
Хүснэгт 30 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/	22
Хүснэгт 31 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/.....	22
Хүснэгт 33 ББСБ-аас гаргасан өрийн бичиг /мянган төгрөгөөр/.....	22
Хүснэгт 34 Өрийн бичиг /валютаар/.....	23
Хүснэгт 36 Төслийн зээл санхүүжилт /сая төгрөгөөр/.....	23
Хүснэгт 37 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/.....	24
Хүснэгт 38 Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/.....	24
Хүснэгт 39 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/	25
Хүснэгт 40 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/	25
Хүснэгт 41 Хуримтлагдсан ашиг/алдагдал /тэрбум төгрөгөөр/.....	25
Хүснэгт 43 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, мянган төгрөгөөр/	26
Хүснэгт 44 Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/	27
Хүснэгт 45 2023 оны II улирлын байдлаарх валютын арилжааны мэдээ /тэрбум төгрөгөөр/	28
Хүснэгт 46 Гадаад валютын арилжааны мэдээ /2023 оны II улирал/	28
Хүснэгт 47 ЗХШҮ /үзүүлэлт бүрээр/.....	29

Зургийн жагсаалт

Зураг 1 Банкны салбарт эзлэх хувь (нийт актив, зээл).....	11
Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	11
Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	12
Зураг 5 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/	14
Зураг 6 Зээлийн багцын чанар /хувиар/.....	14
Зураг 7 Олгосон зээл /хугацааны ангиллаар/	15
Зураг 8 Ногоон зээлийн багцын чанар /ногоон таксономийн 8 ангиллаар/.....	18
Зураг 9 Банкны салбарт эзлэх хувь (өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг).....	20
Зураг 10 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	21
Зураг 11 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/.....	21
Зураг 12 Бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ-ууд /мянган төгрөгөөр/	22
Зураг 13 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/.....	23
Зураг 14 Хувьцаат капиталын бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	24
Зураг 15 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/	26

Товчилсон нэрсийн жагсаалт

Товчилсон нэр	Тайлбар
Хороо	Санхүүгийн зохицуулах хороо
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
ЗГВА	Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг
УБ	Улаанбаатар хот
ХОН	Хөдөө орон нутаг
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалттай
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт
ӨБҮХХ	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө
ӨБХ	Өмчлөх бусад хөрөнгө
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
ЗХШҮ	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал

2023 оны II улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 522 ББСБ байгаа нь өмнөх оны мөн үеэс 5 ББСБ буюу 0.9 хувиар буурсан үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-уудын 95 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 25 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 5 ББСБ байна.

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл

	2019-II	2020-II	2021-II	2022-II	2023-II
Шинээр олгосон	5	12	7	11	19
Хүчингүй	6	8	3	18	8
Түдгэлзүүлсэн	6	25	1	41	2
Сэргээсэн	6	4	5	9	16
Нийт ББСБ	538	542	536	527	522
Үүнээс: ХОН	75	77	79	89	95
Үүнээс: ГХО	27	31	30	27	25
Салбар	235	278	308	405	445
Төлөөлөгч	7	9	8	7	9

2023 оны II улирлын байдлаар 19 хуулийн этгээдэд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 8 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 2 ББСБ-ын үйл ажиллагааг түдгэлзүүлж, 16 ББСБ-ын үйл ажиллагааг сэргээсэн байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгохоос гадна уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2023 оны II улирлын байдлаар 42 ББСБ үзүүлж байна.

Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2022-II	2023-II	Өсөлтийн хувь
Нийт хөрөнгө	3,182.7	3,945.9	24.0%
Банкны салбартай харьцуулахад хувиар	7.5%	8.2%	0.7%
Нийт өөрийн хөрөнгө	1,981.6	2,468.2	24.6%
Банкны салбартай харьцуулахад хувиар	48.8%	49.4%	0.6%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	1,230.0	1,440.0	17.1%
Банкны салбартай харьцуулахад хувиар	76.8%	86.7%	9.9%
Нийт зээл	2,497.8	3,107.5	24.4%
Банкны салбартай харьцуулахад хувиар	10.5%	12.0%	1.5%
Нийт орлого	392.0	520.2	32.7%
Нийт зарлага	242.8	331.1	36.4%
Цэвэр ашиг	149.2	189.1	26.8%

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 24.0 хувиар өсөж, банкны салбарын 8.2%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын 86.7%-тай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.9 пунктээр өссөн дүн юм.

2023 оны II улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 24.0 хувиар буюу 763.2 тэрбум төгрөгөөр өсөж 3.9 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 79.9 хувийг зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 63.8 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ББСБ-уудын нийт орлогын хэмжээ 32.7 хувиар буюу 128.2 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 36.4 хувиар буюу 88.3 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 26.8 хувиар буюу 39.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2022-II	2023-II	Тоо	Хувь
	Нийт ББСБ-ын тоо	527	522	-5	-0.9%
1	Зээл	489	481	-8	-1.6%
	<i>Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг</i>	318	339	21	6.6%
2	Факторингийн үйлчилгээ	42	50	8	19.0%
3	Төлбөрийн баталгаа гаргах	28	29	1	3.6%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	5	6	1	20.0%
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	36	42	6	16.7%
6	Гадаад валютын арилжаа	141	143	2	1.4%
	<i>Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг</i>	38	39	1	2.6%
7	Итгэлцлийн үйлчилгээ	59	82	23	39.0%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	21	26	5	23.8%
9	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	1	1	-	-

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 522 ББСБ 9 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 92.1% нь буюу 481 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба үүнээс 64.9% нь буюу 339 ББСБ дагнан эрхэлж байна. Харин гадаад валютын

арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа 143 ББСБ байгаа нь нийт ББСБ-уудын 27.4 хувийг, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлж байгаа 39 ББСБ нийт ББСБ-уудын 7.5 хувийг бүрдүүлж байна.

Зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 1.6 хувиар буурч, бусад төрлийн үйл ажиллагааны тоо нэмэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл итгэлцлийн үйлчилгээ 39.0 хувиар, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээ 23.8 хувиар, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйл ажиллагаа 20.0 хувиар, факторинг 19.0 хувиар тус тус өссөн байна. Зөвшөөрлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 669 дүгээр тогтоолоор нэр бүхий 39 ББСБ-ын хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх тусгай зөвшөөрлийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болгосон ба 2023 оны II улирлын байдлаар 25 ББСБ тусгай зөвшөөрлөө хүчингүй болгосон тухай өөрчлөлтөө улсын бүртгэлийн ерөнхий газар бүртгүүлсэн байна.

2023 оны II улирлын тайлан мэдээний ирц 97.7% байна. Тайлан мэдээг ирүүлбэл зохих 522 ББСБ-аас 510 ББСБ улирлын тайлан мэдээ ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 6 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр, нэр бүхий 6 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

Өмнөх улирлын байдлаар нэгтгэлд хамрагдсан 6 ББСБ-аас 2 ББСБ-ын үйл ажиллагааг түдгэлзүүлэх арга хэмжээг Хяналт шалгалт зохицуулалтын газраас авч хэрэгжүүлсэн байна.

Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт

Банк бус санхүүгийн байгууллагын салбарт мөрдөгдөх дүрэм, журмуудыг хууль тогтоомжид нийцүүлэн шинээр боловсруулах, шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах арга хэмжээний хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

- “[Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам](#)”-д Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 36 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж, Хууль зүй, дотоод хэргийн яамд 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 1/283 тоот албан бичгээр өөрчлөлтийг хүргүүлж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүллээ.

- 2023 оны II улиралд Цахим зөвлөлийн хуралдаанаар журмын шаардлага хангасан [26 ББСБ-ын 24 аппликэйшнийг Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд бүртгэсэн](#) байна. Финтек зээлийн үйлчилгээний эрх зүйн орчин бүрдсэнтэй холбоотойгоор цахим зээл олгож байгаа ББСБ-уудыг 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор журамд заасан шаардлагыг ханган бүртгүүлэх хугацаа өгсөн бол шинээр финтек зээлийн үйлчилгээ эрхлэх ББСБ-ууд нь журмын шаардлагыг ханган, бүртгүүлэх хүсэлтээ ирүүлэх боломжтой. Журам батлагдсанаас хойш зөвшөөрөлгүй финтек зээлийн үйлчилгээ эрхэлж буй ББСБ-уудад журамд заасан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 498 дугаар тушаалаар Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нийцүүлэн холбогдох дүрэм, журам, зааврыг боловсруулах, судалгаа шинжилгээ хийх ажлын хэсгийг байгуулсан бөгөөд СЗХ-ны 2023.03.13-ны өдрийн 81 дүгээр тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам”, 82 дугаар тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бүртгэлийн дэвтэр хөтлөх,

тайлан мэдээ ирүүлэх журам”, 83 дугаар тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох”, 84 дүгээр тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны сургалтын журам”, 85 дугаар тогтоолоор “Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн ажиллах журам”-ыг тус тус баталж, Хууль зүй, дотоод хэргийн яамны [Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 6484-6488](#) тоот дугаарт бүртгүүллээ.

- Банкны тухай хуулийн 6.2-т заасны дагуу 2 банканд факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл олголоо. 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор Хаан банканд, 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 97 дугаар тогтоолоор Худалдаа хөгжлийн банканд тус тус олгосон байна.

- Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг Улаанбаатар хотод 5,000,000,000 /таван тэрбум/ төгрөг, Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Дархан сумдад 1,200,000,000 /нэг тэрбум хоёр зуун сая/ төгрөг, бусад аймаг, сумдад 400,000,000 /дөрвөн зуун сая/ төгрөг байхаар тус тус тогтоосон ба итгэлцлийн үйлчилгээ эрхэлж буй банк бус санхүүгийн байгууллагуудын хувьд 3 жил дараалан үе шаттай нэмэгдүүлэхээр тогтоосныг Хууль зүй, дотоод хэргийн яамны [Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 6222 тоот дугаарт бүртгүүлсэн](#) байна.

- Банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулах түүнд хяналт тавих журамд Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 220 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж, Хууль зүй, дотоод хэргийн яамны [Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд 2023 оны 7 дугаар сарын 05-ны өдөр холбогдох хөдөлгөөн хийгдэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтлэгдсэн байна.](#)

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт

2023 оны II улирлын байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 85.4 хувь буюу 434 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 80.5 хувь буюу 409 ББСБ хэрэгжүүлсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу ББСБ-ууд нь Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах, гэрээ байгуулж мэдээлэл солилцох үүрэгтэй.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн А-57 дугаар тушаалаар “Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журам”-ыг шинэчлэн баталсантай холбоотойгоор Монголбанкнаас мэдээлэл нийлүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг нэгдсэн журмаар шинэчлэн байгуулах ажлыг зохион байгуулж, тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 477 ББСБ-ын 88.5% буюу 422 ББСБ гэрээгээ шинэчлэн байгуулсан байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А-264, А-265 дугаар тушаалаар Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг “Бүрэн скор ЗМС” ХХК болон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК авсан. Ингэснээр 2022 оны 11 дүгээр сарын 01-ээс эхлэн Монголбанкны зээлийн мэдээллийн лавлагаа олгох үйл ажиллагаа зогсож дээрх 2 компаниудын

үйл ажиллагаа эхэлж байна. Иймд ББСБ-ууд дээрх 2 компаниудтай гэрээгээ шинэчлэн байгуулж хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллах шаардлагатай байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу нэр бүхий 110 ББСБ, 6823 удаагийн тохиолдлоор, 1,270.4 сая төгрөгийг, 7.2-т “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.” гэж заасны дагуу нэр бүхий 4 ББСБ, 13 удаагийн тохиолдлоор, 1,520.6 сая төгрөгийг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

2023 оны II улирлын байдлаар нийт 513 ББСБ-аас 1,255.5 сая төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төлөхөөс 92.4% буюу 463 ББСБ 1,160.2 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

Статистик үзүүлэлтүүд

2023 оны II улирлын байдлаар давхардсан тоогоор 28,366 хувьцаа эзэмшигчдийн 522 ББСБ, 445 салбар нэгж, 8 төлөөлөгчийн газар, 5,012 ажилтантайгаар Монгол улсын 20 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 3.9 сая харилцагч, 1.3 сая зээлдэгчид хүрч үйлчилж байна.

Харилцагчид, зээлдэгчид

Нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 18.0 хувиар буурч давхардсан тоогоор 3,895,981-д, зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 12.9 хувиар буурч 1,322,326-д хүрсэн байна.

Хүснэгт 4 Харилцагч, зээлдэгчдийн мэдээлэл

Статистик мэдээлэл	Дун	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Нийт харилцагчдын тоо	3,895,981	3,339,065	272,983	3,622,998	42,134	3,870,841	25,140	335,126	101,720
Үүнээс: Эмэгтэй	2,121,676	1,820,794	139,717	1,981,959	17,769	2,107,433	14,243	185,179	54,894
Эрэгтэй	1,768,447	1,517,402	127,960	1,640,487	20,596	1,757,606	10,841	149,681	46,515
Хуулийн этгээд	5,858	869	5,306	552	3,769	5,802	56	266	311
Итгэмжлэгчдийн тоо	6,797	6,796	2,019	4,778	-	6,789	8	2,565	291
Өрийн бичиг авсан харилцагчдын тоо	1,594	1,514	150	1,444	-	1,569	25	1,182	402
Зээлдэгчдийн тоо	1,322,326	819,709	217,328	1,104,998	-	1,297,319	25,007	189,927	101,720
Хэвийн	1,153,693	694,520	189,547	964,146	-	1,133,055	20,638	159,781	84,256
Хугацаа хэтэрсэн	49,830	38,429	8,666	41,164	-	48,525	1,305	8,508	4,481
Чанаргүй:	118,803	86,760	19,115	99,688	-	115,739	3,064	21,638	12,983
-Хэвийн бус	37,821	27,300	7,892	29,929	-	36,762	1,059	7,505	4,577
-Эргэлзээтэй	39,173	28,959	4,113	35,060	-	38,360	813	8,254	5,758
-Муу	41,809	30,501	7,110	34,699	-	40,617	1,192	5,879	2,648
Зээлдэгчдийн насжилт	1,320,575	818,898	216,072	1,104,503	-	1,295,622	24,953	189,661	101,409
18-35 насны	811,514	475,469	94,690	716,824	-	799,222	12,292	112,048	60,165
36-45 насны	323,700	211,923	72,206	251,494	-	316,143	7,557	49,424	25,452
46-55 насны	147,298	100,033	35,892	111,406	-	143,486	3,812	22,263	12,465
55-аас дээш	38,016	31,426	13,283	24,733	-	36,724	1,292	5,926	3,327
Зээлдэгчдийн боловсрол	1,320,575	818,898	216,072	1,104,503	-	1,295,622	24,953	189,661	101,409
-Дээд	713,025	497,195	117,072	595,953	-	700,322	12,703	114,347	66,538
-Тусгай дунд	116,127	59,571	21,384	94,743	-	113,145	2,982	21,388	13,545
-Бүрэн дунд	344,786	179,321	52,431	292,355	-	336,852	7,934	43,820	16,283
-Дунд	96,446	57,497	9,091	87,355	-	95,564	882	8,170	4,399
-Бага	50,145	25,267	16,093	34,052	-	49,693	452	1,936	644

/Финтек ББСБ-ууд финтек, уламжлалт зээл хослуулан олгодог болно/

Нийт харилцагчдын 93.0% буюу 3,622,998 нь, зээлдэгчдийн 83.6% буюу 1,104,998 нь санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж /финтек/, онлайн зээлийн үйлчилгээ нэвтрүүлж буй ББСБ-уудын харилцагч, зээлдэгч байгаа бол нийт харилцагчдын 7.0% буюу 272,983 нь, зээлдэгчдийн 16.4% буюу 217,328 нь уламжлалт ББСБ-ын харилцагч, зээлдэгч байна. Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудын харилцагчид 42,134 буюу нийт харилцагчдын 1.1 хувийг бүрдүүлж байна.

Хувьцаа эзэмшигчид болон ажилчид

Хүснэгт 5 Статистик мэдээлэл /5 жилээр/

Үзүүлэлтүүд	2019-II	2020-II	2021-II	2022-II	2023-II	Өөрчлөлт	
						Дүнгээр	Хувиар
Хувьцаа эзэмшигчдийн тоо	7,618	8,404	21,486	22,378	28,366	5,988	26.8%
Ажилчдын тоо	2,921	3,372	3,713	4,279	5,012	733	17.1%
Харилцагчдын тоо	2,348,014	2,766,913	3,292,164	4,748,336	3,895,981	(852,355)	-18.0%
Зээлдэгчдийн тоо	360,345	445,984	748,270	1,518,497	1,322,326	(196,171)	-12.9%
Зээлийн жигнэсэн дундаж хүү	3.4%	2.9%	2.9%	3.1%	3.3%	+0.2%	

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо өмнөх оны мөн үеэс 26.8 хувиар буюу 5,988-аар өсөж 28,366-д хүрчээ. Нийт хувьцаа эзэмшигчдийн 96.4 хувь буюу 27,332 нь олон нийтэд хувьцаагаа санал болгосон ББСБ-уудын хувьцаа эзэмшигч байгаа бол 1,034 буюу 3.6% нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн 2,606 буюу 9.2% нь гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байгаа бол 212 буюу 0.7% нь хөдөө орон нутгийн ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байна.

Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Хувьцаа эзэмшигчдийн тоо	28,366	27,528	1,870	26,496	57	28,155	211	27,332	2,609
Нийт ажилтнуудын тоо	5,012	2,832	2,787	2,225	112	4,733	279	424	433
Үүнээс: Эмэгтэй ажилтны тоо	2,825	1,611	1,569	1,256	62	2,631	194	263	257
Эрэгтэй ажилтны тоо	2,187	1,221	1,218	969	50	2,102	85	161	176

Хөдөө орон нутгийн 95 ББСБ 6 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа

	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ТЗ-тэй ББСБ-ын тоо	522	82	483	39	39	427	95	5	517	25
1 Зээл	481	82	442	39	-	389	92	5	476	25
2 Факторингийн үйлчилгээ	50	26	34	16	-	50	-	3	47	2
3 Төлбөрийн баталгаа гаргах	29	16	22	7	-	28	1	2	27	5
4 Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	6	5	1	5	-	6	-	1	5	-
5 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	42	21	27	15	-	40	2	3	39	1
6 Гадаад валютын арилжаа	143	34	127	16	39	132	11	4	139	7
7 Итгэлцлийн үйлчилгээ	82	82	59	23	-	79	3	5	77	7
8 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	26	18	18	8	-	24	2	2	24	4
9 Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	1	1	1	-	-	1	-	-	1	1

Тархалт

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 81.8% буюу 427 ББСБ, салбаруудын 62.7% буюу 279 салбар байршиж байна. Харин хөдөө орон нутагт нийт ББСБ-ын 18.2% буюу 95 ББСБ, салбаруудын 37.3% буюу 166 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

2023 оны II улирлын байдлаар 95 ББСБ-ын 445 салбар бүртгэлтэй байгаа ба эдгээрийн 62.0хувийг 13 ББСБ-ын 276 салбар бүрдүүлж байна.

Хүснэгт 8 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт

Дүүрэг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	427	279	706	100.0%
Сүхбаатар дүүрэг	144	41	185	26.2%
Чингэлтэй дүүрэг	117	41	158	22.4%
Баянгол дүүрэг	72	41	113	16.0%
Баянзүрх дүүрэг	45	66	111	15.7%
Хан-Уул дүүрэг	39	32	71	10.1%
Сонгинохайрхан дүүрэг	9	49	58	8.2%
Багануур дүүрэг	1	5	6	0.8%
Налайх дүүрэг	-	4	4	0.6%

ББСБ-ууд хөдөө орон нутгаас Орхон, Төв, Өвөрхангай аймгуудад, Улаанбаатар хотоос Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдэд хамгийн ихээр төвлөрч үйлчилгээгээ хүргэж байна.

Хүснэгт 9 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт

Аймаг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	95	166	261	100%
Архангай аймаг	3	7	10	3.8%
Баян-Өлгий аймаг	3	4	7	2.7%
Баянхонгор аймаг	5	8	13	5.0%
Булган аймаг	2	2	4	1.5%
Говь-Алтай аймаг	1	2	3	1.1%
Говьсүмбэр аймаг	2	3	5	1.9%
Дархан-Уул аймаг	8	13	21	8.0%
Дорноговь аймаг	1	9	10	3.8%
Дорнод аймаг	5	13	18	6.9%
Дундговь аймаг	-	5	5	1.9%
Завхан аймаг	2	4	6	2.3%
Орхон аймаг	11	16	27	10.3%
Өвөрхангай аймаг	10	12	22	8.4%
Өмнөговь аймаг	2	14	16	6.1%
Сүхбаатар аймаг	5	7	12	4.6%
Сэлэнгэ аймаг	6	11	17	6.5%
Төв аймаг	18	6	24	9.2%
Увс аймаг	4	7	11	4.2%
Ховд аймаг	1	5	6	2.3%
Хөвсгөл аймаг	3	9	12	4.6%
Хэнтий аймаг	3	9	12	4.6%

Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


2023 оны II улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 3.9 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.0 хувиар буюу 763.2 тэрбум төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 79.9 хувийг нийт зээлийн өсөлт бүрдүүлж байна. Активын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Активын үзүүлэлтүүд	2022-II дүн	Нийт дүнд эзлэх хувь	2023-II дүн	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
					дүн	хувь
<i>Эргэлтийн хөрөнгө</i>	3,079,600.9	96.8%	3,815,144.8	96.7%	735,543.9	23.9%
Мөнгөн хөрөнгө	391,313.1	12.3%	524,573.9	13.3%	133,260.8	34.1%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	16,756.3	0.5%	34,911.5	0.9%	18,155.3	108.3%
Зээл (цэврээр)	2,367,245.0	74.4%	2,929,953.4	74.3%	562,708.4	23.8%
<i>Нийт зээл</i>	2,497,786.3	78.5%	3,107,490.5	78.8%	609,704.2	24.4%
<i>(Зээлийн эрсдэлийн сан)</i>	130,541.3	4.1%	177,537.1	4.5%	46,995.8	36.0%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	9,488.1	0.3%	10,247.3	0.3%	759.3	8.0%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	18,596.2	0.6%	21,439.2	0.5%	2,843.0	15.3%
Бусад хөрөнгө	276,135.8	8.7%	288,870.7	7.3%	12,734.9	4.6%
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл (дериватив)-ийн авлага	66.6	-	5,148.8	0.1%	5,082.2	-
<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>	103,132.3	3.2%	130,753.7	3.3%	27,621.3	26.8%
Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө	133,019.0	4.2%	169,547.7	4.3%	36,528.7	27.5%
(Хуримтлагдсан элэгдэл)	-29,886.7	-0.9%	-38,794.1	-1.0%	-8,907.4	29.8%
Нийт хөрөнгийн дүн	3,182,733.3	100.0%	3,945,898.4	100.0%	763,165.2	24.0%


2023 оны II улирлын байдлаар ББСБ-уудын нийт актив банкны салбарын нийт активын 8.2 хувьтай, нийт зээлийн үлдэгдэл 12.0 хувьтай тэнцэж байна.

Зураг 1 Банкны салбарт эзлэх хувь (нийт актив, зээл)



Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлтийг харвал салбарын нийт актив 2018 оны мөн үед 1,143.7 тэрбум төгрөг байсан бол 2023 оны II улирлын байдлаар 3.5 дахин өсөж 3,945.9 тэрбум төгрөгт хүрчээ. Энэ нь цэвэр зээлийн үлдэгдэл 4.0 дахин өссөнтэй холбоотой.

Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Салбарын нийт хөрөнгийн 95.2% нь 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хөрөнгөтэй 341 ББСБ, 2.9% нь 1.9-2.5 тэрбум төгрөг хүртэлх активтай 52 ББСБ байгаа бол нийт салбарын хөрөнгийн 1.9 хувийг 1.9 тэрбум төгрөг хүртэлх активтай 129 ББСБ-ын хөрөнгө бүрдүүлж байна.

Хүснэгт 11 Активын интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	3,047.4	118	77.2%	22.6%	9.7	1	6.5	1	5.3	1
2.5-5.0 тэрбум	708.0	223	17.9%	42.7%	8.0	2	6.0	2	3.2	1
1.9-2.5 тэрбум	115.1	52	2.9%	10.0%	-	-	6.7	3	2.4	1
1.4-1.9 тэрбум	19.7	12	0.5%	2.3%	3.0	2	6.4	4	-	-
0.6-1.4 тэрбум	28.2	30	0.7%	5.7%	11.1	12	9.5	10	5.2	6
0.6 тэрбум хүртэлх	27.5	87	0.7%	16.7%	-	-	16.5	57	11.0	30
НИЙТ	3,945.9	522	100.0%	100.0%	31.8	17	51.6	77	27.1	39

Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын актив 2.0 их наяд төгрөг байгаа нь нийт активын 50.5 хувийг, нийт зээлийн үлдэгдэл 1.7 их наяд төгрөг байгаа нь нийт зээлийн үлдэгдлийн 53.8 хувийг бүрдүүлж байна.

Мөнгөн хөрөнгө


Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 133.3 тэрбум төгрөгөөр буюу 34.1 хувиар өсөж 524.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Бүтцээр нь авч үзвэл 21.8% нь бэлэн мөнгө хэлбэрээр, 47.5% нь банк, санхүүгийн байгууллагын харилцах дансанд 30.7% нь банк, санхүүгийн байгууллагын хадгаламжийн дансанд байршиж байна.

Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
МӨНГӨН ХӨРӨНГӨ	524.6	243.5	355.4	169.2	26.9	508.4	16.2	47.7	54.9
Бэлэн мөнгө	114.2	12.3	111.0	3.2	18.1	106.2	7.9	0.0	5.6
Харилцах	249.4	114.7	156.8	92.5	8.1	244.3	5.1	39.1	40.3
Хадгаламж	161.1	116.5	87.6	73.5	0.7	157.9	3.1	8.6	9.0

ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл уламжлалт үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 31.2%, финтек ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 1.9%, эрхэлж буй үйл ажиллагааны онцлогоос хамаарч гадаад валютын арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын 67.0% нь бэлэн мөнгө хэлбэрээр тус тус байршиж байна.

Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 2.1 дахин буюу 18.2 тэрбум төгрөгөөр өсөж, 2023 оны II улирлын байдлаар 34 ББСБ 34.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан байна. Богино хугацаат хөрөнгө оруулалтын 45.7% буюу 16.0 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын үнэт цаас, 54.5% буюу 19.0 тэрбум төгрөгийг арилжааны үнэт цаас бүрдүүлж байна. Төрлөөр авч үзвэл 54.2% буюу 18.9 тэрбум төгрөг нь хувьцаа, 44.8% буюу 15.6 тэрбум төгрөг нь өрийн бичгээр, 1.3% буюу 452.2 сая төгрөг нь бусад үнэт цаасаарх хөрөнгө оруулалт байна.

Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/

	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
БХХО (ЦЭВРЭЭР)	34,911.5	31,657.9	7,049.7	27,861.8	1.0	34,112.1	799.5	17,285.6	14,613.4
Хувьцаа	18,912.1	16,849.5	4,882.7	14,029.4	1.0	18,113.6	798.5	11,934.4	9,931.8
Өрийн бичиг	15,635.9	14,735.9	1,875.0	13,760.9	-	15,635.9	-	5,211.4	4,703.0
Бусад	452.2	161.2	291.0	161.2	-	451.2	1.0	161.2	-
ЗГ-ын үнэт цаас	1.0	1.0	1.0	-	-	1.0	-	-	-
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	15,960.9	13,997.8	1,963.1	13,997.8	-	15,903.0	57.8	10,173.0	9,931.8
Арилжааны үнэт цаас	19,040.3	17,749.8	5,086.6	13,953.7	1.0	18,298.7	741.6	7,134.0	4,703.0

Тайлант улиралд богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрөлтэй 26 ББСБ бүртгэлтэй байгаа хэдий ч 34 ББСБ санхүүгийн тайлангаар богино хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан байна. Эдгээрийн талаас бага хувь нь буюу тусгай зөвшөөрөлтэй 16 ББСБ-ын холбогдох дансанд 31.2 тэрбум төгрөг бүртгэлтэй байна.

Засгийн газрын бондыг эрсдэлгүй гэж үзэн СЗХ-оос тухайн төрлийн бондыг тусгай зөвшөөрөлгүйгээр авах боломжтой гэж үзсэн хэдий ч санхүүгийн тайлангийн Засгийн газрын үнэт цаас хэсэгт 1 ББСБ 1.0 сая төгрөгийн үнэт цаас бүртгэсэн байна.

Иймээс 18 ББСБ тусгай зөвшөөрөлгүй энэхүү үйл ажиллагааг эрхэлсэн байгаа тул Зөрчлийн тухай хуульд заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

Факторингийн тооцооны авлага

Факторингийн тооцооны авлага өмнөх оны мөн үеэс 8.6% буюу 764.0 сая төгрөгөөр өсөж, 16 ББСБ 10.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ. 2023 оны II улирлын байдлаар 5 ББСБ 727.0 сая төгрөгийн анхаарал хандуулах болон чанаргүй факторингийн үлдэгдэлд 227.6 сая төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 10.2 тэрбум төгрөгийн цэвэр факторингийн тооцооны авлагын үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 14 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/

Нийт факторингийн тооцооны авлага	2022-II		2023-II		Өөрчлөлт	
	Нийт дүн	Эзлэх хувь	Нийт дүн	Эзлэх хувь	Нийт дүн	Эзлэх хувь
	9,642.2	100.0%	10,475.0	100.0%	832.8	8.6%
Хэвийн	8,984.0	93.2%	9,748.0	93.1%	764.0	8.5%
Анхаарал хандуулах	341.6	3.5%	107.1	1.0%	(234.4)	-68.6%
Чанаргүй	316.6	3.3%	619.9	5.9%	303.3	95.8%
Хэвийн бус	124.9	1.3%	392.9	3.8%	268.0	214.6%
Эргэлзээтэй	171.8	1.8%	205.9	2.0%	34.1	19.8%
Муу	19.9	0.2%	21.1	0.2%	1.2	6.1%
(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	154.1	1.6%	227.6	2.2%	73.5	47.7%

Факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэмэгдсэн хэдий ч факторингийн тусгай зөвшөөрөлтэй 50 ББСБ-уудын 34 ББСБ нь тусгай зөвшөөрөл олгосноос хойш үйл ажиллагаа эрхлэхгүй байгаа тул журамд заасны дагуу тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох шаардлагатай гэж үзэж байна.

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеэс 6.3 тэрбум төгрөг буюу 38.9 хувиар өсөж 22.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 15 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ӨБҮХХ БОЛОН ӨБХ (ЦЭВРЭЭР)	21,439.2	11,556.7	16,368.1	5,071.0	21,439.1	0.1	927.4	20,511.8	2,409.0
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	26,558.4	15,251.0	18,046.9	8,511.6	26,558.4	-	2,931.0	23,627.4	2,719.2
(ӨБҮХХ-ийн болзошгүй эрсдэлийн сан)	7,955.5	5,196.9	4,008.9	3,946.6	7,955.5	-	2,178.7	5,776.7	1,929.1
Өмчлөх бусад хөрөнгө	2,836.2	1,502.6	2,330.1	506.1	2,836.1	0.1	175.1	2,661.1	1,618.9

Зээл

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 24.4% буюу 609.7 тэрбум төгрөгөөр өсөж 2023 оны II улирлын байдлаар 3,107.5 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 177.5 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 2,929.9 тэрбум төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.


Хүснэгт 16 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	2,930.0	1,980.2	1,492.7	1,437.2	2,872.1	57.9	505.9	2,424.1	448.1
Нийт зээл	3,107.5	2,085.5	1,592.4	1,515.1	3,043.6	63.9	521.2	2,586.3	464.2
Хэвийн	2,766.9	1,878.5	1,403.3	1,363.6	2,711.0	55.9	482.1	2,284.8	425.9
Анхаарал хандуулах	103.1	66.9	56.5	46.6	101.8	1.4	14.4	88.7	13.3
Чанаргүй:	237.4	140.0	132.5	104.9	230.8	6.6	24.6	212.8	25.1
-Хэвийн бус	64.4	43.2	28.7	35.7	63.3	1.1	10.1	54.3	8.2
-Эргэлзээтэй	62.8	38.3	31.1	31.7	62.2	0.6	9.4	53.4	7.7
-Муу	110.2	58.6	72.7	37.5	105.3	4.9	5.1	105.1	9.2
(Зээлийн эрсдэлийн сан)	177.5	105.3	99.7	77.9	171.5	6.1	15.3	162.2	16.1
Нийт зээл (төгрөгийн)	3,025.2	2,013.5	1,577.5	1,447.7	2,961.6	63.6	490.5	2,534.7	430.3
Нийт зээл (валютын)	82.3	71.9	14.9	67.3	82.0	0.3	30.6	51.7	34.0
Зээлдэгчдийн тоо	1,322,326	819,709	217,328	1,104,998	1,297,319	25,007	189,927	1,132,399	101,720
- Иргэн	1,320,575	818,898	216,072	1,104,503	1,295,622	24,953	189,661	1,130,914	101,409
- Хуулийн этгээд	1,751	811	1,256	495	1,697	54	266	1,485	311

/Финтек ББСБ-ууд уламжлалт зээл давхар олгодог болно/


Тайлант улиралд ББСБ-ууд 3.2 их наяд төгрөгийн зээлийг 3.3 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 2.8 их наяд төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2023 оны II улирлын байдлаар 1,322,326 зээлдэгчийн 3.1 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Зураг 4 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/



Нийт зээлийн үлдэгдлийн 89.0 хувийг буюу 2.7 их наяд төгрөгийг хэвийн зээл, 3.3 хувийг буюу 103.1 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 7.7 хувийг буюу 237.4 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Зураг 5 Зээлийн багцын чанар /хувиар/



Нийт зээлд эзлэх хэвийн болон анхаарал хандуулах зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс харгалзан 0.1, 0.6 пунктээр буурсан бол чанаргүй зээлийн хэмжээ 0.7 пунктээр өссөн байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 340.6 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 52.1%-д буюу 177.5 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна. 2023 оны II улирлын байдлаар нийт зээлд эзлэх анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ 11.0% байна.

Олгосон зээлийн 90.4% буюу 2.9 их наяд төгрөгийн зээлийг иргэдэд, 9.6% буюу 309.3 тэрбум төгрөгийн зээлийг хуулийн этгээдэд олгосон байгаа бол 90.8% буюу 2.6 их наяд төгрөг нь иргэдээс, 9.2% нь буюу 259.4 тэрбум төгрөг нь хуулийн этгээдээс эргэн төлөгдсөн байна.


Хүснэгт 17 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /сая төгрөгөөр/

№	Зээлийн эдийн засгийн ангилал	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1.	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	12,809.0	0.4%	13,215.0	0.5%	26,891.9	0.9%
2.	Уул уурхай, олборлолт	26,547.8	0.8%	19,710.8	0.7%	55,906.7	1.8%
3.	Боловсруулах үйлдвэрлэл	21,971.4	0.7%	21,146.5	0.7%	35,875.7	1.2%
4.	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	2,853.9	0.1%	2,526.8	0.1%	5,438.8	0.2%
5.	Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	1,131.9	0.0%	1,354.2	0.0%	1,775.1	0.1%
6.	Барилга	123,719.6	3.8%	101,928.1	3.6%	227,700.9	7.3%
7.	Бөөний болон жижиглэн худалдаа	273,473.0	8.5%	243,082.1	8.6%	348,569.8	11.2%
8.	Машин мотоциклийн засвар үйлчилгээ	64,563.1	2.0%	61,350.5	2.2%	99,412.4	3.2%
9.	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	55,922.6	1.7%	22,507.2	0.8%	76,073.5	2.4%
10.	Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	51,895.0	1.6%	33,917.6	1.2%	110,870.9	3.6%
11.	Мэдээлэл холбоо	8,922.6	0.3%	6,202.5	0.2%	13,050.9	0.4%
12.	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	70,568.1	2.2%	66,105.2	2.3%	54,589.3	1.8%
13.	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	18,660.7	0.6%	7,348.6	0.3%	29,459.5	0.9%
14.	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2,658.2	0.1%	2,813.9	0.1%	4,857.5	0.2%
15.	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	9,419.6	0.3%	11,396.1	0.4%	19,215.9	0.6%
16.	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	655.4	0.0%	935.5	0.0%	1,680.7	0.1%
17.	Боловсрол	8,610.1	0.3%	8,456.9	0.3%	17,637.4	0.6%
18.	Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа	6,727.9	0.2%	7,451.2	0.3%	11,435.3	0.4%
19.	Бусад	2,464,734.5	76.4%	2,201,609.0	77.7%	1,967,048.3	63.3%
	<i>Иргэнд олгосон зээл</i>	2,916,540.0	90.4%	2,573,620.3	90.8%	2,739,913.8	88.2%
	<i>Хуулийн этгээдэд олгосон зээл</i>	309,304.4	9.6%	259,437.5	9.2%	367,576.7	11.8%
	НИЙТ	3,225,844.5	100.0%	2,833,057.7	100.0%	3,107,490.5	100.0%

Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны дарга нарын хамтарсан 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 319/А/16 тоот тушаалаар баталсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-аар нийт олгосон зээлийн 76.4% буюу 2.5 их наяд төгрөг нь бусад ангилалд /ихэвчлэн хэрэглээний зээл/, 8.5% буюу 273.5 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгогдсон бол нийт төлөгдсөн зээлийн 77.7% буюу 2.2 их наяд төгрөг нь бусад ангиллын зээлээс, 8.6% буюу 243.1 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон зээлээс эргэн төлөгджээ.

Зураг 6 Олгосон зээл /хугацааны ангиллаар/

Тайлант улиралд олгосон 3.1 их наяд төгрөгийн зээлийг хугацааны ангиллаар харвал 1 сар хүртэлх хугацаатай олгосон зээл нийт зээлийн 27.3 хувийг, 1-1.5 жилийн хугацаатай олгосон зээл нийт зээлийн 17.0 хувийг буюу хамгийн өндөр хувийг бүрдүүлж байна.



Нийт зээлийн үлдэгдлийн ангиллаас харахад 3.1 их наядын зээлийн 52.8 хувийг иргэний хэрэглээний зээлийн үлдэгдэл, үүнээс 21.6 хувийг автомашинд зориулсан зээлийн үлдэгдэл, 9.6 хувийг хуулийн этгээдийн бизнесийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Зээлийн ангиллаар	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь
Иргэнд олгосон зээл	2,916.5	90.4%	2,573.6	90.8%	2,739.9	88.2%
Хэрэглээнд зориулсан зээл	2,052.0	63.6%	1,889.1	66.7%	1,640.4	52.8%
Үүнээс: Автомашинд зориулсан зээл	390.5	12.1%	290.4	10.3%	672.2	21.6%
Бизнес зориулсан зээл	474.3	14.7%	359.3	12.7%	679.8	21.9%
Үл хөдлөх эд хөрөнгөд зориулсан зээл	85.8	2.7%	63.6	2.2%	170.5	5.5%
Бусад зээл	304.4	9.4%	261.6	9.2%	249.2	8.0%
Хуулийн этгээдэд олгосон зээл	309.3	9.6%	259.4	9.2%	367.6	11.8%
Бизнесийн зээл	264.7	8.2%	227.9	8.0%	298.3	9.6%
Автомашинны зээл	5.1	0.2%	3.9	0.1%	9.4	0.3%
Үл хөдлөх эд хөрөнгийн зээл	6.8	0.2%	6.1	0.2%	13.2	0.4%
Бусад зээл	32.8	1.0%	21.5	0.8%	46.7	1.5%
НИЙТ	3,225.8	100.0%	2,833.1	100.0%	3,107.5	100.0%

Цахим зээл

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй финтек зээлийн үйлчилгээг 2023 оны II улирлын байдлаар 42 ББСБ үзүүлж байна. 1 ББСБ өмнөх улирлын тайлангаар хамрагдсан бол 3 ББСБ шинээр бүртгүүлсэн байна.

Хүснэгт 19 Зээлийн ангилал

	Зээлийн дүн	Нийт дүнд эзлэх хувь	Зээлдэгчдийн тоо	Нийт дүнд эзлэх хувь	Дундаж зээл
Уламжлалт	2,592,245,931.2	83.4%	300,650	22.7%	8,622.1
Цахим зээл	515,244,565.2	16.6%	1,021,676	77.3%	504.3
Нийт	3,107,490,496.4	100.0%	1,322,326	100.0%	2,350.0

2023 оны II улирлын байдлаар эдгээр ББСБ-ууд зөвхөн аппликэйшний 1,021,676 зээлдэгчийн 515.2 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт зээлдэгчийн 77.3 хувь, нийт зээлийн үлдэгдлийн 16.6 хувийг бүрдүүлж байна. Зөвхөн аппликэйшнээр нэг зээлдэгчид дунджаар 504.3 мянган төгрөгийн зээл олгосон байгаа нь уламжлалт зээлийн дунджаас 17.1 дахин бага байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 160 дугаар тогтоолоор “[Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам](#)”-ыг баталсан. Уг журам нь Хууль зүйн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 5807 дугаарт бүртгэгдэж, [Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлийн 2022 оны 13 дугаарт](#) нийтлэгдсэнээр финтек зээл олгож байгаа ББСБ-уудын эрх зүйн орчин бүрдсэн.

Энэхүү тогтоолын 3 дугаар заалтад өмнө финтек зээлийн үйлчилгээ эрхэлж байсан ББСБ-ууд 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор журамд заасан шаардлагыг ханган Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэхийг үүрэг болгосон ба [журмын хэрэгжилтийг хангаж хугацаандаа бүртгүүлсэн 26 ББСБ](#) 24 аппликэйшнээр зээл олгохоор бүртгүүлсэн байна. “Ньюстар финанс ББСБ” ХХК 2 аппликэйшн бүртгүүлсэн бол Rocket аппликэйшнээр зээл олгохоор 4 ББСБ мэдэгдсэн байна.

Хүснэгт 20 Цахим зээл олгож байгаа ББСБ-ууд

№	Финтек	Апп нэр	Бүртгүүлсэн огноо	Бүртгүүлсэн дугаар
1	Жи Би Си Си	E-zeel	2023.03.03	7/889
2	Нөмөр кредит	numur	2023.03.03	7/890
3	Энт кредит инвестмент	EntcreditMN	2023.03.03	7/891
4	Хатан суудал инвест	Zeely	2023.03.03	7/894
5	Соно финтек	Sono Mongolia	2023.03.03	7/895
6	Онч-Энх	Ugloo	2023.03.30	7/1297
7	Есөн эрдэнэ финанс	Leasing.mn	2023.03.30	7/1298
8	Инвекор хэтгэвч	Pocket	2023.05.08	7/1871
9	Гэрэлфинанс	Gerel	2023.05.08	7/1872
10	Тус финтек	TUS Fintech	2023.05.19	7/2125
11	Мобифинанс	Monpay	2023.06.20	7/2540
12	ТОКИ	Toki	2023.06.20	7/2549
13	Хас хаан	ХАС ХААН	2023.06.20	7/2551
14	Ньюстар финанс	Nsf.mn, Lite+	2023.06.20	7/2552, 7/2553
15	Лэндмн	LendMN	2023.06.20	7/2558
16	Сэндли	Sendly	2023.07.04	7/2821

17	Гурван зуун жар финанс	Minu Pay	2023.07.04	7/2822
18	Франкфурт капитал	Narapp	2023.07.04	7/2823
19	Нанокапитал	Nano Capital	2023.07.04	7/2824
20	Нэт капитал финанс корпораци	Netpay	2023.07.04	7/2825
21	Таван богд финанс	PayOn	2023.07.04	7/2826
22	Грийн-Инвестмент	Gate	2023.07.04	7/2827
23	Зээл Эм Эн платформ	Zeel.mn	2023.07.04	7/2828
24	Инвекор	Pocket	МЭДЭГДСЭН	
25	Цогзолфинанс	Pocket	МЭДЭГДСЭН	
26	Мөнгөнзоос кредит	Pocket	МЭДЭГДСЭН	
27	Ардкредит	Ard	Бүртгэгдээгүй	
28	Ашид капитал	Simple, Simple Agent	Бүртгэгдээгүй	
29	Бизнес-Инвест девелопмент	БИД app	Бүртгэгдээгүй	
30	Говьфинанс	CashOne Lite, CashOne	Бүртгэгдээгүй	
31	Грийн финтек	t finance, green fintech	Бүртгэгдээгүй	
32	Жи Эс Би Капитал	GSB Prime, Mongolchat	Бүртгэгдээгүй	
33	Кэйш флов финанс	tugrug app	Бүртгэгдээгүй	
34	Монголиа импакт финанс	Qmoni	Бүртгэгдээгүй	
35	Начин заан финанс	Naizly	Бүртгэгдээгүй	
36	Нэмэх төгрөг	Most Money	Бүртгэгдээгүй	
37	Омни капитал	Moni Digital	Бүртгэгдээгүй	
38	Очир ундраа ОМЗ	Opay	Бүртгэгдээгүй	
39	Өсөх ундарга финанс	ufinance	Бүртгэгдээгүй	
40	Смарткапитал фонд	My Credit	Бүртгэгдээгүй	
41	Фин экспрессе	Finex	Бүртгэгдээгүй	
42	Централ капитал	kmobi	Бүртгэгдээгүй	

Ногоон зээл

Тайлант хугацаанд 25 ББСБ 3,379 зээлдэгчид 58.3 тэрбум төгрөгийн зээлийг дунджаар 2.0 хувийн хүүтэйгээр олгож, 26 ББСБ-ын 13,569 зээлдэгчээс 45.4 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2023 оны II улирлын байдлаар 33 ББСБ 7,542 зээлдэгчийн 127.2 тэрбум төгрөгийн “ногоон” зээлийн үлдэгдэлтэй гарчээ. Энэ нь салбарын нийт зээлийн үлдэгдлийн 4.1%-тай тэнцэж байна. Үүнээс 5-аас дээш жилийн ашиглалтын жилтэй тээврийн хэрэгслийн дүнг хасаж тооцвол ногоон зээлийн үлдэгдэл нийт зээлийн үлдэгдлийн “0.3” хувийг бүрдүүлж байна.


Хүснэгт 21 Ногоон зээлийн тайлан /сая төгрөгөөр/

НОГООН ТАКСОНОМИ ҮНДСЭН 8 АНГИЛАЛ	Олгосон зээлийн		Төлөгдсөн зээлийн		Зээлийн эцсийн үлдэгдлийн	
	Дүн	Зээлдэгчдийн тоо	Дүн	Зээлдэгчдийн тоо	Дүн	Зээлдэгчдийн тоо
1. СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ	297.1	25	4.9	13	293.2	26
2. БАГА БОХИРДУУЛАГЧ ЭРЧИМ ХҮЧ	-	-	0.0	1	100.0	1
3. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ	79.7	33	213.9	80	2,390.8	84
4. НОГООН БАРИЛГА	2,258.7	183	2,207.4	252	6,356.8	27
5. БОХИРДЛООС СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	-	-	-	-	50.0	2
6. ТОГТВОРТОЙ УС, ХАЯГДЛЫН ХЭРЭГЛЭЭ	-	-	-	-	-	-
7. ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ, ГАЗАР АШИГЛАЛТ, ОЙ БОЛОН ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ	72.0	1	134.6	13	853.0	15
8. КАРБОН БАГА ЯЛГАРУУЛДАГ ТЭЭВЭР	55,576.2	3,137	42,801.3	13,210	117,143.0	7,387
Үүнээс:						
0-5 хүртэлх жилийн ашиглалтын жилтэй тээвэр	1,506.9	19	682.3	28	967.7	60
5-10 хүртэлх жилийн ашиглалтын жилтэй тээвэр	33,743.3	1,650	30,598.8	9,817	75,543.5	4,918
10-аас дээш жилийн ашиглалтын жилтэй тээвэр	20,326.0	1,468	11,520.3	3,365	40,631.8	2,409
НИЙТ	58,283.6	3,379	45,362.1	13,569	127,186.8	7,542

Ногоон зээлийн үлдэгдлийн 92.1% буюу 117.1 тэрбум төгрөгийг карбон бага ялгаруулдаг тээврийн хэрэгслийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Тогтвортой ус, хаягдлын хэрэглээний салбаруудад зээлийн үлдэгдэл байхгүй байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 95.1% нь хэвийн, 3.2% нь анхаарал хандуулах, 1.5% нь чанаргүй ангилалд ангилагдсан ба Ногоон барилгын салбарын зээлийн үлдэгдэл хамгийн их буюу 2.1% нь чанаргүй ангилалд ангилагдсан байна.

Зураг 7 Ногоон зээлийн багцын чанар /ногоон таксономийн 8 ангиллаар/



Бусад хөрөнгө

2023 оны II улирлын байдлаарх 288.9 тэрбум төгрөгийн бусад хөрөнгийн үлдэгдлийн 50.8% буюу 146.9 тэрбум төгрөг нь хуримтлуулж тооцсон хүүгийн авлага, 28.1% буюу 81.1 тэрбум төгрөг нь дансны цэвэр авлага, 21.1% буюу 60.9 тэрбум төгрөг нь бусад актив байна.

Хүснэгт 22 Бусад хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
БУСАД ХӨРӨНГӨ	288,870.7	168,126.1	182,696.2	106,174.5	12.0	282,974.9	5,895.8	33,194.8	255,675.9
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	146,888.7	80,275.8	94,783.8	52,104.8	-	144,861.4	2,027.2	13,070.3	133,818.3
-Үнэт цаасны	295.5	295.5	40.2	255.2	-	295.5	-	179.5	116.0
-Зээлийн	140,891.9	75,403.7	91,661.1	49,230.8	-	138,891.9	2,000.0	12,305.3	128,586.5
-Факторингийн	277.1	210.9	57.6	219.5	-	277.1	-	-	277.1
-Бусад	5,424.2	4,365.8	3,024.9	2,399.3	-	5,397.0	27.2	585.5	4,838.7
Авлага /цэврээр/	81,122.7	53,508.5	53,139.4	27,983.4	3.7	78,507.0	2,615.7	12,527.4	68,595.4
Нийт авлага	84,535.8	56,655.3	53,857.8	30,678.1	3.7	81,914.4	2,621.4	13,401.3	71,134.6
Хэвийн	77,578.2	52,425.8	50,541.4	27,036.8	0.2	74,970.3	2,607.9	12,517.3	65,060.9
Хугацаа хэтэрсэн	564.7	491.4	71.9	492.9	3.5	556.4	8.3	5.5	559.3
Чанаргүй:	6,392.9	3,738.0	3,244.5	3,148.4	-	6,387.7	5.2	878.5	5,514.4
-Хэвийн бус	607.2	598.7	12.9	594.2	-	607.2	-	5.4	601.8
-Эргэлзээтэй	858.5	68.1	790.4	68.1	-	858.5	-	1.8	856.7
-Муу	4,927.3	3,071.3	2,441.2	2,486.1	-	4,922.1	5.2	871.4	4,055.9
Нийт авлага (валютын)	65,669.3	38,333.2	35,778.2	29,891.1	3.7	63,047.9	2,621.4	13,401.3	52,268.0
Нийт авлага (төгрөгийн)	18,866.6	18,322.1	18,079.6	787.0	-	18,866.6	-	0.0	18,866.6
(Авлагын эрдэлийн сан)	3,413.1	3,146.8	718.4	2,694.7	-	3,407.4	5.7	873.9	2,539.2
Бусад актив	60,859.3	34,341.8	34,773.0	26,086.3	8.3	59,606.5	1,252.8	7,597.0	53,262.2

Эргэлтийн бус хөрөнгө

ББСБ-ууд 2023 оны II улирлын байдлаар 169.5 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлд 38.8 тэрбум төгрөгийн элэгдлийг хуримтлуулж бүртгэсэн байна. Ингэснээр тайлант хугацаанд 130.8 тэрбум төгрөгийн биет ба биет бус хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 23 Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

ҮНДСЭН (БИЕТ) БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	169.5	91.8	88.4	81.2	0.3	165.6	4.0	15.7	16.2
Барилга байгууламж	56.8	38.8	23.4	33.4	0.1	55.4	1.4	2.9	2.4
Техник хэрэгсэл	59.9	23.5	42.9	17.0	0.0	58.2	1.8	3.4	5.2
Тавилга эд хогшил	20.6	12.1	11.1	9.6	0.2	20.1	0.5	4.0	4.7
Дуусаагүй барилга	7.2	1.9	5.1	2.1	0.0	7.2	0.0	0.1	-
Биет бус хөрөнгө	25.0	15.5	5.9	19.1	0.0	24.7	0.3	5.3	3.9
(Хуримтлагдсан элэгдэл)	38.8	20.8	22.8	16.0	0.1	37.7	1.1	4.8	4.5
Барилга байгууламжийн	8.1	6.2	2.7	5.4	0.0	7.9	0.2	1.5	0.1
Техник хэрэгслийн	22.2	9.4	15.6	6.6	0.0	21.5	0.7	1.8	2.6
Тавилга эд хогшлын	8.5	5.2	4.5	3.9	0.1	8.3	0.2	1.4	1.8

Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт

Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 24.0 хувиар буюу 763.2 тэрбум төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 36.2 хувийг өр төлбөрийн өсөлт, 63.8 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Пассивын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:


Хүснэгт 24 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Пассивын үзүүлэлтүүд	2022-II	Нийт дүнд	2023-II	Нийт дүнд	Өөрчлөлт	
	дүн	эзлэх хувь	дүн	эзлэх хувь	дүн	хувь
Өр төлбөр	1,201,117.0	37.7%	1,477,743.9	37.5%	276,627.0	23.0%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	300,270.9	9.4%	449,317.7	11.4%	149,046.9	49.6%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	395,080.3	12.4%	428,239.4	10.9%	33,159.1	8.4%
Бусад эх үүсвэр	54,213.7	1.7%	48,563.1	1.2%	(5,650.6)	-10.4%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	196,584.7	6.2%	237,947.7	6.0%	41,363.0	21.0%
Төслийн зээлийн санхүүжилт	20,707.4	0.7%	33,284.0	0.8%	12,576.7	60.7%
Бусад өр төлбөр	234,260.1	7.4%	280,392.1	7.1%	46,132.0	19.7%
Эздийн өмч	1,981,616.3	62.3%	2,468,154.5	62.5%	486,538.2	24.6%
Хувьцаат капитал	1,230,040.1	38.6%	1,440,023.5	36.5%	209,983.4	17.1%
Бусад өмч	45,885.9	1.4%	61,586.5	1.6%	15,700.5	34.2%
Сангууд	2,290.7	0.1%	1,274.9	0.0%	(1,015.8)	-44.3%
Хуримтлагдсан ашиг/алдагдал	632,854.6	19.9%	889,274.6	22.5%	256,420.1	40.5%
Хоёрдогч өглөг	70,545.0	2.2%	75,995.0	1.9%	5,450.0	7.7%
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	3,182,733.3	100.0%	3,945,898.4	100.0%	763,165.2	24.0%

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өр төлбөрөөс итгэлцлийн үйлчилгээний өглөг 49.6 хувиар, төслийн зээлийн санхүүжилт 60.7 хувиар ББСБ-аас гаргасан өрийн бичиг 21.0 хувиар өссөн бол өөрийн хөрөнгөөс хуримтлагдсан ашиг 40.5 хувиар, бусад өмч 34.2 хувиар тус тус өссөн байна.


Сүүлийн 5 жилийн өөрийн хөрөнгийн үзүүлэлтүүдийг банкны салбартай харьцуулбал 2018 оны мөн үед өөрийн хөрөнгө банкны салбарын 25.6 хувьд хүрдэг байсан бол 2023 оны II улирлын байдлаар 49.4 хувьд хүрч байна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2019 оны эхний хагас жилээс 2021 оны III улирал хүртэл банкны салбарын хувь нийлүүлсэн хөрөнгийг давдаг байсан бол 2023 оны II улиралд 86.7 хувьтай тэнцэж байна. Хуримтлагдсан ашгийн хувьд өмнөх оны мөн үед 32.9 хувьтай тэнцдэг байсан бол 2023 оны II улирлаар 3.8 пунктээр өсөж 36.7 хувьтай тэнцэж байна.

Зураг 8 Банкны салбарт эзлэх хувь (өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг)



Сүүлийн 5 жилийн пассивын үзүүлэлтийг харвал 2023 оны II улирлын байдлаар салбарын нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 2018 оны мөн үетэй харьцуулахад 2.8 дахин өсөж 2.3 их наяд төгрөгт, өр төлбөрийн хувьд 5.9 дахин өсөж 1.4 их наяд төгрөгт хүрсэн байна.


Зураг 9 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Итгэлцлийн үйлчилгээний өглөг

2023 оны II улирлын байдлаар өр төлбөрөөс хамгийн өндөр өсөлтийг итгэлцлийн үйлчилгээний өглөг үзүүлсэн байна. Өмнөх оны мөн үеэс 49.6% буюу 149.0 тэрбум төгрөгөөр өсөж, итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 82 ББСБ-аас 71 ББСБ 6,797 итгэмжлэгчээс 449.3 тэрбум төгрөгийн итгэлцэл татан төвлөрүүлсэн байна.

Зураг 10 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/



Улаанбаатар хотын 69 ББСБ 6,789 итгэмжлэгчээс 447.9 тэрбум төгрөг, хөдөө орон нутгийн 2 ББСБ 8 итгэмжлэгчээс 1.4 тэрбум төгрөгийн хөрөнгө татан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 25 Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/

Итгэлцлийн үйлчилгээний өглөг	Дүн	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	449.3	126.2	323.1	447.9	1.4	154.2	295.1	106.7
-Төгрөгөөр	375.5	116.9	258.5	374.0	1.4	115.2	260.2	106.7
-Валютаар	73.9	9.3	64.5	73.9	-	39.0	34.9	90.9
Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ын тоо	82	59	23	79	3	5	77	7
-Үүнээс итгэлцлийн үйлчилгээний өглөгтэй ББСБ-уудын тоо	71	49	22	69	2	5	66	6
Нийт итгэмжлэгчдийн тоо	6,797	2,019	4,778	6,789	8	2,565	4,232	291

Хамгийн өндөр дүнгээр буюу 90.0 тэрбум төгрөгийг 199 итгэмжлэгчээс татан төвлөрүүлсэн бол хамгийн олон итгэмжлэгчээс буюу 1,854 итгэмжлэгчээс нийт 14.5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг

2023 оны II улирлын байдлаар дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг 8.4 хувиар өсөж, 108 ББСБ дотоод, гадаадын банк болон санхүүгийн байгууллагаас 428.2 тэрбум төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт 26 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/

Банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
	428.2		349.1	187.9	240.4	426.0	2.2	106.3	321.9	106.4
Хугацаагаар:										
Богино хугацаат зээл	186.5	43.6%	155.8	102.8	83.7	186.0	0.5	40.3	146.2	42.1
Урт хугацаат зээл	241.7	56.4%	193.3	85.1	156.6	240.0	1.7	66.0	175.7	64.3
Валютын төрлөөр:										
Төгрөгөөр	358.4	83.7%	297.4	152.5	205.8	356.2	2.2	83.5	274.9	68.9
Валютаар	69.9	16.3%	51.7	35.3	34.5	69.9	-	22.9	47.0	37.5
Зээл авсан байгууллагаар:										
Дотоодын банк, санхүүгийн байгууллагаас	365.2	85.3%	303.5	153.3	211.9	363.0	2.2	89.5	275.7	73.1
Зээл /төгрөгөөр/	358.4	83.7%	297.4	152.5	205.8	356.2	2.2	83.5	274.9	68.9
Зээл /валютаар/	6.8	1.6%	6.0	0.8	6.0	6.8	-	6.0	0.8	4.2
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас	63.0	14.7%	45.7	34.5	28.5	63.0	-	16.8	46.2	33.3

Бусад эх үүсвэр

2023 оны II улирлын байдлаар 17 ББСБ 48.6 тэрбум төгрөгийн бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй гарчээ. Үүнээс нэр бүхий 5 ББСБ 8.1 тэрбум төгрөгийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгийн үлдэгдэлтэй, нэр бүхий 3 ББСБ 7.2 сая төгрөгийн төлбөр тооцооны үйлчилгээний өглөгийн үлдэгдэлтэй, нэр бүхий 8 ББСБ 32.8 тэрбум төгрөгийн факторингийн үйлчилгээний өглөгтэй, нэр бүхий 1 ББСБ 387.0 сая төгрөгийн гадаад валютын арилжааны эх үүсвэрийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 27 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/

Бусад эх үүсвэр	Дүн	Эзлэх хувь	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХК
Нийт	48,563.1	100.0%	36,020.4	13,111.4	35,451.7	48,563.1	182.9
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	8,143.4	16.8%	7,006.0	6,554.7	1,588.7	8,143.4	182.9
Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	7,221.6	14.9%	7,001.4	220.2	7,001.4	7,221.6	-
Факторингийн үйлчилгээний өглөг	32,811.1	67.6%	22,013.1	5,949.5	26,861.6	32,811.1	-
Гадаад валютын арилжааны эх үүсвэр	387.0	0.8%	-	387.0	-	387.0	-

Өмнөх оны мөн үеэс мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг 22.4 хувиар, факторингийн үйлчилгээний өглөг 24.2 хувиар тус тус буурсан байна. Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг 20.2 дахин нэмэгдсэн байна.

Зураг 11 Бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ-ууд /мянган төгрөгөөр/

Бусад эх үүсвэр	2019-II	2020-II	2021-II	2022-II	2023-II
Зээлийн батлан даалтад байршуулсан эх үүсвэр	-	66,950.0	-	51,000.0	-
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	3,109,707.0	7,784,808.7	11,315,823.5	10,495,497.1	8,143,434.0
Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	3,800,574.1	199,379.1	111,472.7	357,852.6	7,221,554.2
Факторингийн үйлчилгээний өглөг	8,134,245.2	25,179,367.1	37,156,838.3	43,309,198.2	32,811,105.7
Гадаад валютын арилжааны эх үүсвэр	-	-	-	112.5	387,000.0
Нийт	15,044,526.3	33,230,505.0	48,584,134.5	54,213,660.4	48,563,093.9

Хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа болон гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудаас бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ байхгүй байна.

ББСБ-аас гаргасан өрийн бичиг


2023 оны II улирлын байдлаар 39 ББСБ нээлттэй болон хаалттай хүрээнд өрийн бичиг гаргаж, үүнийг 1,594 хувь хүн, хуулийн этгээд худалдан авсан ба нийт 237.9 тэрбум төгрөгийн өрийн бичгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 28 ББСБ-аас гаргасан өрийн бичиг /мянган төгрөгөөр/

ББСБ-ААС ГАРГАСАН ӨРИЙН БИЧИГ	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
	237,947.7	219,133.8	39,984.7	197,962.9	236,800.7	1,146.9	66,736.1	171,211.5	44,224.8
Төгрөгөөр	225,838.8	207,251.1	39,758.6	186,080.2	224,691.9	1,146.9	66,736.1	159,102.7	44,224.8
Валютаар	12,108.8	11,882.7	226.1	11,882.7	12,108.8	-	-	12,108.8	-


Өрийн бичгийн үлдэгдэл 2018 оны мөн үеэс 14.3 дахин өсөж 237.9 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Зураг 12 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Өмнөх оны мөн үед валютаар гаргасан өрийн бичгийн нийт өрийн бичгийн үлдэгдэлд эзлэх хувийн жин 6.6 хувь байсан бол 2023 оны II улирлын байдлаар 0.8 пунктээр буурч 5.1 хувьд хүрсэн байна.

Хүснэгт 29 Өрийн бичиг /валютаар/



Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 263 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журам”-ыг хүчингүй болгосонтой холбогдуулан 2023 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн ББСБ-ууд өрийн бичиг гаргахдаа “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллана.

Төслийн зээлийн санхүүжилт

Төсөл хөтөлбөрөөс 14 ББСБ 33.2 тэрбум төгрөгийг төслийн санхүүжилтээр эх үүсвэр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт 30 Төслийн зээл санхүүжилт /сая төгрөгөөр/

ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТ	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
	33,284.0		16,743.5	25,790.2	7,493.9	31,905.1	1,378.9	6,792.5	26,491.6	8,131.6
Хугацаагаар										
Богино хугацаат	8,525.0	25.6%	4,767.3	3,882.9	4,642.1	8,381.2	143.8	3,940.7	4,584.3	-
Урт хугацаат	24,759.0	74.4%	11,976.1	21,907.3	2,851.7	23,523.9	1,235.1	2,851.7	21,907.3	8,131.6
Төрлөөр										
Засгийн газрын	701.4	0.02	701.4	-	701.4	701.4	-	-	701.4	-
Гадаадын	11,782.2	35.4%	10,924.0	6,989.7	4,792.5	11,782.2	-	4,792.5	6,989.7	6,131.6
Дотоодын	8,034.5	24.1%	5,118.0	6,034.5	2,000.0	6,705.6	1,328.9	2,000.0	6,034.5	2,000.0
Бусад	12,766.0	38.4%	-	12,766.0	-	12,716.0	50.0	-	12,766.0	-
Валютын төрлөөр										
Төгрөгөөр	28,819.6	86.6%	13,652.1	21,325.8	7,493.9	27,440.7	1,378.9	6,792.5	22,027.2	5,040.2
Валютаар	4,464.4	13.4%	3,091.4	4,464.4	-	4,464.4	-	-	4,464.4	3,091.4

Бусад өр төлбөр

2023 оны II улирлын байдлаар 477 ББСБ 280.4 тэрбум төгрөгийн бусад өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Үүний 15.4% буюу 43.3 тэрбум төгрөг нь 84 ББСБ-ын хуримтлуульж тооцсон хүүгийн өглөг, 82.8% буюу 232.2 тэрбум төгрөг нь 477 ББСБ-ын бусад пассивын үлдэгдэл байна.

Хүснэгт 31 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/

БУСАД ӨР ТӨЛБӨР	Дүн	Итгэллэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Хуримтлуульж тооцсон хүүгийн өглөг	43,307.2	33,798.7	8,742.3	34,565.0	136.6	43,258.7	48.5	10,750.4	32,556.8	7,639.8
Ангиллаар										
Эзлийн	17,224.8	8,066.1	4,342.2	12,882.6	136.6	17,191.6	33.2	2,297.8	14,927.0	1,047.9
Үнэт цаасны	4,138.6	3,923.2	180.8	3,957.8	-	4,138.6	-	1,529.9	2,608.7	1,067.6
Бусад	21,943.8	21,809.4	4,219.3	17,724.5	-	21,928.5	15.3	6,922.8	15,021.0	5,524.3
Валютын төрлөөр										
Төгрөгөөр	39,587.2	30,482.9	8,061.4	31,525.8	136.6	39,538.7	48.5	9,414.1	30,173.1	6,394.8
Валютаар	3,720.1	3,315.8	680.9	3,039.2	-	3,720.1	-	1,336.4	2,383.7	1,245.0
Бусад пассив	232,170.7	154,056.9	115,444.7	116,726.0	2,722.3	229,037.7	3,133.0	63,749.4	168,421.2	52,330.6

Хувь нийлүүлсэн хөрөнгө

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 17.1% буюу 210.0 тэрбум төгрөгөөр өсөж 1.4 их наяд төгрөгт хүрсэн ба энэ нь нийт пассивын 36.5 хувийг бүрдүүлж байна.


Хүснэгт 32 Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/

Хувьцаат капитал	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Энгийн хувьцаа	1,442,372.1	526,511.4	1,102,891.6	339,469.5	18,445.4	1,386,935.2	55,437.0	42,641.1	1,399,731.0	109,210.5
Давуу эрхтэй хувьцаа	199.3	36.0	199.3	-	-	157.0	42.3	-	199.3	121.0
Халаасны хувьцаа	2,548.0	2,548.0	210.4	2,337.5	-	2,548.0	-	2,341.1	206.8	3.6

Хувьцаат капиталын хэмжээ 2018 оны мөн үеэс 1.6 дахин өсөж 1.4 их наяд төгрөгт, үүнээс энгийн хувьцаа 1.6 дахин өсөж 1.4 их наяд төгрөгт, давуу эрхийн хувьцаа 3.7 дахин буурч 199.3 сая төгрөгт, халаасны хувьцаа 12.3 дахин өсөж 2.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.

2023 оны II улирлын байдлаар 522 ББСБ-ын 1.4 их наяд төгрөгийн энгийн хувьцаа, 3 ББСБ-ын 199.3 сая төгрөгийн давуу эрхийн хувьцаа, 3 ББСБ-ын 2.5 тэрбум төгрөгийн халаасны хувьцаа бүртгэгдсэн байна.

Зураг 13 Хувьцаат капиталын бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



1.9 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 393 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 96.3% буюу 1.4 их наяд

төгрөг байна. Харин 1.9 тэрбум төгрөг хүртэлх хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 129 ББСБ-ын 53.7 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 3.7 хувийг, ББСБ-уудын 24.7 хувийг бүрдүүлж байна.

Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 286.6 тэрбум төгрөг байгаа нь нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 19.9 хувийг, бусдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн дүн 1.1 их наяд төгрөг байгаа нийт дүнгийн 74.3 хувийг бүрдүүлж байгаа зэргээс харахад томоохон ББСБ-ууд бусдаас хөрөнгө татан төвлөрүүлж үйл ажиллагаагаа явуулж байгаа тул хяналт шалгалтыг сайжруулах нь зүйтэй.

Хүснэгт 33 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	ХНХ	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	449.8	35	31.2%	6.7%	7.3	1	-	-	-	-
2.5-5.0 тэрбум	827.3	302	57.5%	57.9%	2.5	1	7.0	2	3.0	1
1.9-2.5 тэрбум	109.2	56	7.6%	10.7%	-	-	1.9	1	-	-
1.4-1.9 тэрбум	9.8	7	0.7%	1.3%	2.8	2	4.2	3	1.4	1
0.6-1.4 тэрбум	18.3	23	1.3%	4.4%	7.8	11	5.3	6	2.9	3
0.6 тэрбум хүртэлх	25.6	99	1.8%	19.0%	0.5	1	14.0	65	10.3	31
НИЙТ	1,440.0	522	100.0%	100.0%	20.8	16	32.4	77	17.5	36

Бусад өмч, сангууд

Бусад өмч өмнөх оны мөн үеэс 34.2 хувиар өсөж 61.6 тэрбум төгрөгт, сангууд 44.3 хувиар буурч 1.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт 34 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/


	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Бусад өмч	61,586.5	55,793.4	15,242.3	46,344.2	87.9	61,283.2	303.3	50,185.1	11,401.4	39,288.8
НТК	57,140.8	54,343.2	12,291.4	44,849.3	52.8	57,001.7	139.0	50,127.8	7,013.0	39,283.9
Дахин үнэлгээний нэмэгдэл	2,437.7	708.9	1,713.4	724.3	-	2,398.7	39.0	-	2,437.7	4.9
Хандивын капитал	2,008.0	741.3	1,237.4	770.6	35.0	1,882.8	125.2	57.3	1,950.7	-
Сангууд	1,274.9	96.4	1,246.5	28.3	-	437.8	837.1	4.4	1,270.5	64.3
Нөөцийн сан	689.6	45.8	706.1	(16.5)	-	116.3	573.3	(16.6)	706.2	62.3
Нийгмийн хөгжлийн сан	585.3	50.6	540.4	44.9	-	321.5	263.8	21.0	564.3	2.0

Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашиг өмнөх оны мөн үеэс 40.5% буюу 256.4 тэрбум төгрөгөөр өсөж 889.3 тэрбум төгрөгт хүрчээ.

Тайлант хугацаанд 462 ББСБ нийт 903.5 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бол 7 ББСБ үйл ажиллагаа эрхлээгүй, 53 ББСБ 14.2 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Хүснэгт 35 Хуримтлагдсан ашиг/алдагдал /тэрбум төгрөгөөр/




Хоёрдогч өглөг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хоёрдогч өглөгийн хэмжээ 7.7 хувиар өсөж 76.0 тэрбум төгрөгт хүрчээ. 2023 оны II улирлын байдлаар 8 ББСБ 76.0 тэрбум төгрөгийн хоёрдогч өглөгийн үлдэгдэлтэй байна.

Ашигт ажиллагаа

2023 оны II улирлын байдлаар ББСБ-ууд 520.2 тэрбум төгрөгийн орлого олж, 331.1 тэрбум төгрөгийн зардал гаргаж 189.1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Зураг 14 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/



Өмнөх оны мөн үеэс орлогын хэмжээ 32.7% буюу 128.2 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 36.4% буюу 88.3 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 26.8% буюу 39.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 36 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, мянган төгрөгөөр/

ОРЛОГО	2022-II	2023-II	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
Хүүгийн орлого	308,583,995.3	439,120,326.9	84.4%	130,536,331.6	42.3%
Хүүгийн бус орлого	72,531,994.5	68,397,063.1	13.1%	-4,134,931.5	-5.7%
-Санхүүгийн үйлчилгээний орлого	44,271,661.6	46,755,164.7	9.0%	2,483,503.1	5.6%
- Итгэлцлийн үйлчилгээний орлого	2,443,479.8	376,966.5	0.1%	-2,066,513.3	-84.6%
- Мөнгөн гүйвүүлгын орлого	1,137,442.6	2,273,722.4	0.4%	1,136,279.8	99.9%
- Картын үйлчилгээний орлого	-	1,602.0	-	1,602.0	-
- Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	44,520.9	-	-	-44,520.9	-100.0%
- Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	33,291,596.8	32,020,320.2	6.2%	-1,271,276.6	-3.8%
- Бусад	7,354,621.5	12,082,553.6	2.3%	4,727,932.1	64.3%
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	10,711,475.1	12,605,188.2	2.4%	1,893,713.1	17.7%
Ердийн бус орлого	171,592.6	107,811.1	0.02%	-63,781.5	-37.2%
НИЙТ ОРЛОГО	391,999,057.5	520,230,389.3	100.0%	128,231,331.8	32.7%
ЗАРДАЛ					
Хүүгийн зардал	43,156,003.1	60,715,329.4	18.3%	17,559,326.4	40.7%
Хүүгийн бус зардал	144,908,370.2	189,226,333.6	57.1%	44,317,963.4	30.6%
Болзошгүй эрсдэлийн зардал	33,554,668.2	50,732,716.5	15.3%	17,178,048.3	51.2%
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	3,652,026.8	4,869,106.7	1.5%	1,217,079.9	33.3%
Орлогын албан татварын зардал	17,520,726.2	25,516,362.8	7.7%	7,995,636.6	45.6%
Ердийн бус зардал	17,419.8	56,914.4	-	39,494.6	226.7%
НИЙТ ЗАРЛАГА	242,809,214.4	331,116,763.5	100.0%	88,307,549.1	36.4%
АШИГ					
ЦЭВЭР АШИГ	149,189,843.1	189,113,625.8	100.0%	39,923,782.7	26.8%

Өмнөх оны мөн үеэс хамгийн их өөрчлөлт орсон үзүүлэлтийг харвал орлогын хувьд хүүгийн орлого 42.3 хувиар буюу 130.5 тэрбум төгрөгөөр өсөж 189.1 тэрбум төгрөгт хүрчээ.

2023 оны эхний хагас жилд итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 82 ББСБ-аас 71 ББСБ 6,797 итгэмжлэгчээс 449.3 тэрбум төгрөгийн итгэлцэл татан төвлөрүүлсэн хэдий ч 4 ББСБ 377.0 сая төгрөгийн орлого бүртгэсэн байна. Үүнээс үүдэн итгэлцлийн үйлчилгээний орлого 84.6 хувиар буурсан дүнтэй гарсан бол ББСБ-ын хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээг хүчингүй болгосноор Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлогогүй гарсан байна.

Хүснэгт 37 Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/

ОРЛОГО	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Хүүгийн орлого	439,120.3	310,940.3	197,469.1	241,651.2	23.1	430,766.4	8,353.9	72,274.4	60,551.8
Хүүгийн бус орлого	68,397.1	49,577.3	27,596.4	40,800.7	1,596.0	67,380.9	1,016.2	13,976.3	3,787.3
- Санхүүгийн үйлчилгээний орлого	46,755.2	33,953.0	16,645.1	30,110.0	-	45,762.1	993.0	11,920.4	2,229.5
Итгэлцлийн үйлчилгээний орлого	377.0	377.0	0.3	376.7	-	377.0	-	357.5	-
Мөнгөн гуйвуулгын орлого	2,273.7	1,537.4	2,232.2	41.5	-	2,271.7	2.0	41.5	-
Картын үйлчилгээний орлого	1.6	-	1.6	-	-	1.6	-	-	-
Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	-	-	-	-	-	-	-	-	-
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	32,020.3	28,249.4	5,252.7	26,767.6	-	31,066.3	954.0	11,004.6	1,937.5
Бусад	12,082.6	3,789.2	9,158.3	2,924.2	-	12,045.6	37.0	516.7	292.0
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	12,605.2	8,221.6	8,431.3	4,173.9	0.0	12,309.2	296.0	2,526.1	1,956.4
Ердийн бус орлого	107.8	31.8	107.8	-	-	107.8	0.0	-	-
НИЙТ ОРЛОГО	520,230.4	368,770.9	233,604.6	286,625.8	1,619.0	510,564.3	9,666.1	88,776.8	66,295.6
ЗАРДАЛ									
Хүүгийн зардал	60,715.3	53,361.4	21,247.4	39,467.9	-	60,426.1	289.2	12,054.6	8,355.9
Хүүгийн бус зардал	189,226.3	137,026.6	75,371.5	113,854.9	917.6	185,912.3	3,314.1	36,659.1	28,485.6
Болзошгүй эрсдэлийн зардал	50,732.7	35,588.5	19,846.0	30,886.7	-	49,857.9	874.8	9,123.2	6,000.2
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	4,869.1	2,550.5	2,885.5	1,983.6	0.1	4,785.3	83.8	486.2	961.2
Орлогын албан татварын зардал	25,516.4	18,542.0	11,380.6	14,135.8	15.9	25,255.0	261.4	5,631.9	3,942.6
Ердийн бус зардал	56.9	50.1	56.9	-	-	56.9	-	-	2.4
НИЙТ ЗАРЛАГА	331,116.8	247,119.2	130,788.0	200,328.8	933.6	326,293.5	4,823.2	63,955.0	47,748.0
АШИГ									
ЦЭВЭР ОРЛОГО	189,113.6	121,651.8	102,816.6	86,297.0	685.4	184,270.8	4,842.8	24,821.9	18,547.6

Зөвхөн зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй нэр бүхий 1 ББСБ 1.6 сая картын үйлчилгээний орлого бүртгэсэн байгаа нь зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлсэн байж болзошгүй тул тодруулах шаардлагатай.


Зардлын хувьд өмнөх оны мөн үеэс хамгийн их өсөлт үзүүлсэн нь ердийн бус зардал байна. 3.3 дахин өсөж 56.9 сая төгрөгт хүрсэн байна. Нэр бүхий 7 ББСБ 56.9 сая төгрөг бүртгэсэн ба нэр бүхий 1 ББСБ-ын бүртгэсэн 50.1 сая төгрөгийн ердийн бус зардал 88.1 хувийг бүрдүүлж байна.

ББСБ-ын ердийн үйл ажиллагаанаас илт ялгаатай үйл явдал, ажил гүйлгээнээс үүсдэг байнга давтагдан гарахгүй зардлыг ердийн бус зардал гэнэ. Тухайлбал байгалийн гамшиг болон гэнэтийн ослоос үүссэн гарз хохирол, бэрхшээлтэй өрийн шинэчлэл гэх мэт.

Гадаад валютын арилжааны мэдээ


Тайлант хугацаанд буюу 2023 оны II улиралд гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөлтэй 143 ББСБ-аас 67.8% буюу 97 ББСБ-аас ирүүлсэн тайлангаар 2,173.4 тэрбум төгрөгийн валют худалдан авсан нь банкны салбартай харьцуулахад 10.9 хувьтай тэнцэж байгаа бол 2,132.1 тэрбум төгрөгийн валют зарсан нь банкны салбартай харьцуулахад 10.7 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 38 2023 оны II улирлын байдлаарх валютын арилжааны мэдээ /тэрбум төгрөгөөр/



ББСБ-уудын ирцийн мэдээ сүүлийн 5 жилийн байдлаар дараах байдалтай байна.

Хүснэгт 39 Гадаад валютын арилжааны мэдээ /2023 оны II улирал/



Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

2023 оны II улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 522 ББСБ-ын 86.0% буюу 449 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Нийт ББСБ-уудын 14.0% нь буюу 73 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 58 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 13 ББСБ, 3 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ, 5 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ байна.

Хүснэгт 40 ЗХШҮ /үзүүлэлт бүрээр/

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	Итгэлцэл /82 ББСБ/		Итгэлцэл, ГВА-аас бусад /401 ББСБ/		ЗГВА /39 ББСБ/		Нийт /522 ББСБ/		
		✓	X	✓	X	✓	X	✓	X	
1.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	82	-	400	1	39	-	521	1	
2.	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	82	-	400	1	39	-	521	1	
3.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	82	-	400	1	39	-	521	1	
4.	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	79	3	389	12	39	-	507	15	
5.	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+илүү,- дутуу)	79	3	380	21	38	1	497	25	
6.	Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	82	-	387	14	XXX		508	14	
7.	ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	82	-	401	-				522	-
8.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа	82	-	400	1				521	1
9.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	82	-	396	5				517	5
10.	Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	82	-	401	-				522	-
11.	Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	82	-	400	1				521	1
12.	Монголын хөрөнгийн биржийн “Г”, “П” ангиллын нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа	82	-	401	-				522	-
13.	Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	82	-	401	-				522	-
14.	Бусад үнэт цаас, үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа	82	-	400	1				521	1
15.	Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	82	-	392	9				513	9
16.	Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	81	1	XXX				513	521	
17.	Өрийн бичгийн зохистой харьцаа	82	-	399	2			520	2	
18.	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	80	2	388	13	39	-	507	15	

Тайлбар: ✓ - ЗХШҮ хангасан ББСБ-ын тоо
X - ЗХШҮ хангаагүй ББСБ-ын тоо

ББСБ-уудын хангах ёстой ЗХШҮ-үүдээс хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ дутуу 25 ББСБ, үндсэн хөрөнгийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааны зохистой харьцаа алдагдсан 15 ББСБ, нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа алдагдсан 14 ББСБ, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 9 ББСБ буюу хамгийн их алдагдсан байна.

Бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлсэн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа алдагдсан 9 ББСБ-ын хяналтыг сайжруулж, анхаарч ажиллах шаардлагатай.

Дүгнэлт

2023 оны II улирлын байдлаар тайлан мэдээг ирүүлбэл зохих 522 ББСБ-аас 510 ББСБ улирлын тайлан мэдээ ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 6 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр, нэр бүхий 6 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа. 2023 оны II улирлын байдлаар давхардсан тоогоор 28,366 хувьцаа эзэмшигчдийн 522 ББСБ, 445 салбар нэгж, 8 төлөөлөгчийн газар, 5,012 ажилтантайгаар Монгол улсын 20 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 3.9 сая харилцагч, 1.3 сая зээлдэгчид хүрч үйлчилж байна.

ББСБ-уудын нэгтгэлийн танилцуулгыг боловсруулах явцад бусдаас итгэлцэл болон өрийн бичиг хэлбэрээр эх үүсвэр татсан ББСБ-уудын тухайн үйлчилгээний харилцагчдын тоо нь статистик мэдээлэл болон тухайн тайлангийн дэлгэрэнгүй хэсэгт бөглөсөн тоо мэдээнээс зөрөх, аппликэйшн ашиглан зээл олгож байгаа ББСБ-ууд “Зээл олголт эргэн төлөлт, зээлийн хүүгийн судалгааны тайлан”-г дутуу нөхсөнөөс үүдэн мэдээллийг дахин тодруулах шаардлага үүсэж байна.

Актив, пассивын бүтэц

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 24.0 хувиар өсөж, банкны салбарын 8.2%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын 86.7%-тай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.9 пунктээр өссөн дүн юм.

2023 оны II улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 24.0 хувиар буюу 763.2 тэрбум төгрөгөөр өсөж 3.9 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 79.9 хувийг зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 63.8 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

ББСБ-ууд нь ихэвчлэн өөрийн хөрөнгөд тулгуурлан үйл ажиллагаа эрхэлдэг онцлогтой байсан хэдий ч сүүлийн 2 жилийн хугацаанд бусдаас итгэлцэл, өрийн бичиг, дотоод, гадаадын банк санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөр хэлбэрээр эх үүсвэр татах нь нэмэгдэж байгаа тул тэдгээр /147 ББСБ/ ББСБ-уудын тайлан мэдээнд онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна.

Тайлант улиралд богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрөлтэй 26 ББСБ бүртгэлтэй байгаа хэдий ч 34 ББСБ санхүүгийн тайлангаар богино хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан байна. Эдгээрийн талаас бага хувь нь буюу тусгай зөвшөөрөлтэй 16 ББСБ-ын холбогдох дансанд 31.2 тэрбум төгрөг бүртгэлтэй байна. Засгийн газрын бондыг эрсдэлгүй гэж үзэн СЗХ-оос тухайн төрлийн бондыг тусгай зөвшөөрөлгүйгээр авах боломжтой гэж үзсэн хэдий ч санхүүгийн тайлангийн Засгийн газрын үнэт цаас хэсэгт 1 ББСБ 1.0 сая төгрөгийн үнэт цаас бүртгэсэн байна. Иймээс 18 ББСБ тусгай зөвшөөрөлгүй энэхүү үйл ажиллагааг эрхэлсэн байгаа тул Зөрчлийн тухай хуульд заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 24.4% буюу 609.7 тэрбум төгрөгөөр өсөж 2023 оны II улирлын байдлаар 3,107.5 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 177.5 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 2,929.9 тэрбум төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна. Тайлант улиралд ББСБ-ууд 3.2 их наяд төгрөгийн зээлийг 3.3 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 2.8 их наяд төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2023 оны II улирлын байдлаар 1,322,326 зээлдэгчийн 3.1 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 89.0 хувийг буюу 2.7 их наяд төгрөгийг хэвийн зээл, 3.3 хувийг буюу 103.1 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 7.7 хувийг буюу 237.4 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Нийт зээлд эзлэх хэвийн болон анхаарал хандуулах зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс харгалзан 0.1, 0.6 пунктээр буурсан бол чанаргүй зээлийн хэмжээ 0.7 пунктээр өссөн байна.

Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 340.6 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 52.1%-д буюу 177.5 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 24.0 хувиар буюу 763.2 тэрбум төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 36.2 хувийг өр төлбөрийн өсөлт, 63.8 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад итгэлцлийн үйлчилгээний өглөг 49.6 хувиар, дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг 8.4 хувиар, ББСБ-аас гаргасан өрийн бичгийн үлдэгдэл 21.0 хувиар, төслийн зээлийн санхүүжилт 60.7 хувиар тус тус өссөн байгаа нь ББСБ-уудын хувьд бусдаас өртөг бүхий эх үүсвэрийг татан төвлөрүүлж байгааг харуулж байна.

Ашигт ажиллагаа

2023 оны II улирлын байдлаар ББСБ-ууд 520.2 тэрбум төгрөгийн орлого олж, 331.1 тэрбум төгрөгийн зардал гаргаж 189.1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс орлогын хэмжээ 32.7% буюу 128.2 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 36.4% буюу 88.3 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 26.8% буюу 39.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

2023 оны II улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 522 ББСБ-ын 86.0% буюу 449 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна. Нийт ББСБ-уудын 14.0% нь буюу 73 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна.

ББСБ-уудын хангах ёстой ЗХШҮ-үүдээс хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ дутуу 25 ББСБ, үндсэн хөрөнгийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааны зохистой харьцаа алдагдсан 15 ББСБ, нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа алдагдсан 14 ББСБ, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа алдагдсан 9 ББСБ буюу хамгийн их алдагдсан байна.

Бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлсэн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа алдагдсан 9 ББСБ-ын хяналтыг сайжруулж, анхаарч ажиллах шаардлагатай.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР